АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЭХ
“АЛСЫН ХАРАА - 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар/

2025.08.22 Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Ашигт малтмал, газрын тосны газрын хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны 08 дугаар сарын байдлаар явцын хяналт-шинжилгээ хийж, зорилт, арга хэмжээний хэрэгжилт төлөвлөсөн түвшинд хүрч байгаа эсэхэд үнэлэлт өгч, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

**Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй**

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Ашигт малтмал, газрын тосны газрын хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх журам”-ын шалгуурыг үндэс болгов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Ашигт малтмал, газрын тосны газраас 4 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөгдсөн бөгөөд хэрэгжилт нь 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар, үр дүн хүлээгдэж байгаа 4 /60-84% хувь/, гэж үнэлэгдлээ.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөгөөнд тусгагдсан Аж, үйлдвэр, эрдэс баялагийн яаманд хамаарах чиг үүрэг бүхий арга хэмжээнүүдийг хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулаагүй болно.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Ашигт малтмал, газрын тосны газрын хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1.

| д/д | Арга хэмжээний нэр | Үнэлгээ | | | | | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 85% дээш | 60-84% | 30-59% | 0-29% | Хугацаа болоогүй % | |
| 1 | 4.2.11. Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ. | | √ | | | | 75% |
| 2 | 4.2.12. Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө. | | √ | | | | 75% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 4.2.14. Уул уурхайн ордыг ашиглалтад оруулж, өндөр технологийн хүнд үйлдвэрийн дараах цогцолборуудыг барьж, байгуулна.Үүнд: Уул уурхайн ордууд: ... | | √ | | | | 80% |
| 4 | 4.2.24. Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ. | | √ | | | | 80% |
| **Нийт үнэлгээ** | | | | | | | **77.5%** |

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар **77.5** хувиар үнэлэгдсэн.

Тайлант хугацаанд “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөгөөний 4.2.11 дугаартай “Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд “08 дугаар сарын 22-ний өдрийн байдлаар албажсан 50 тайлангаар техникийн нөхөн сэргээлтийг 371.5 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 235.8 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 113.71 га талбайд нөхөн сэргээлт хийхээр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 535.9 га талбайд 1.3 сая ширхэг мод тарьсан байна” гэж тайлагнасан нь үр дүн хүлээгдэж байна.

Тус бодлогын баримт бичгийн 4.2.24 дугаартай “Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд 2025 онд нийт ашигт малтмалын хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө 1191, үүнээс хайгуулын тусгай зөвшөөрөл дээр хийгдэх хайгуулын ажлын төлөвлөгөө 926, ашиглалтын тусгай зөвшөөрөл дээр хийгдэх хайгуулын ажлын төлөвлөгөө 265, 2024 оны хайгуулын ажлын ирүүлсэн тайлан нийт 1084 байна.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2025.08.08-ны өдрийн байдлаар нөөц хэлэлцүүлэхээр ирүүлсэн 110 хайгуулын ажлын үр дүнгийн тайлангаас хэлэлцсэн 102 үүнээс хүлээн авсан 95 тайлан, буцаасан 7, хэлэлцээгүй 8 байна. Энэ арга хэмжээ нь үр дүн хүлээгдэж байна.

Мөн дээрх бодлогын баримт бичгийн 4.2.12 дугаартай “Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө” гэсэн арга хэмжээний хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газар болон “Бадрах энержи” ХХК-ийн хооронд 2016.09.15-ны өдөр байгуулсан Орд ашиглах гэрээний хэрэгжилтийг дүгнэх тухай ажлын хэсэгт ажиллаж гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гаргасан дүгнэлт, зөвлөмжийг “Бадрах энержи” ХХК-д хүргүүлсэн.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025.03.11-ний өдрийн А/50 дугаар тушаалаар Зөөвч овоо, Дулаан уулын ордыг ашиглах гэрээний шинэчилсэн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж өмнөх гэрээний хэрэгжилтийн талаар ажлын хэсэгт танилцуулж, Орд ашиглах гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Энэ нь үр дүн хүлээгдэж байна.

**Дөрөв. Дүгнэлт**

"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Нэг. "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг **77.5** хувьтай үнэлэгдэв.

**Тав. Зөвлөмж**

"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Нэг. "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаа, зорилтот түвшиндээ хүрч байгаа эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Уул уурхайн хэлтэс, Ашигт малтмал хайгуулын хэлтсийн дарга нарт зөвлөмж болгож байна.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар**

**“АЛСЫН ХАРАА - 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН**
**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2025 он

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2025 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Дөрөв. ЭДИЙН ЗАСАГ | | | | | | | |
| 3 | 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно. | 4.2.11. Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ. | 2020 - 2050 | - | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна. | 2025 оны 8 дугаар сарын байдлаар албажсан 50 тайлангаар техникийн нөхөн сэргээлтийг 371.5 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 235.8 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 113.71 га талбайд нөхөн сэргээлт хийхээр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 535.9 га талбайд 1.3 сая ширхэг мод тарьсан байна.<br>2025 оны ашиглалтын үйл ажиллагааны албажсан 420 төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 6,358.5 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 1,210.9 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 126,645.48 га талбайд нөхөн сэргээлт хийхээр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 онд 22,801.1 га талбайд 20.4 сая мод тарихаар тусгуулан ажилласан. | 75 |
| 4 | | 4.2.12. Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө. | 2020 - 2050 | | Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн байна. | 1. Цагаансуваргын зэс молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төслийн танилцуулга бэлдэж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газарт хүргүүлсэн.<br>2. Ашигт малтмал, газрын тосны газар болон “Бадрах энержи” ХХК-ийн хооронд 2016.09.15-ны өдөр байгуулсан Орд ашиглах гэрээний хэрэгжилтийг дүгнэх тухай ажлын хэсэгт ажиллаж гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гаргасан дүгнэлт, зөвлөмжийг “Бадрах энержи” ХХК-д хүргүүлсэн.<br>Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025.03.11-ний өдрийн А/50 дугаар тушаалаар Зөөвч овоо, Дулаан уулын ордыг ашиглах гэрээний шинэчилсэн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж өмнөх гэрээний хэрэгжилтийн талаар ажлын хэсэгт танилцуулж, Орд ашиглах гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсэн. | 75 |
| 6 | | 4.2.14. Уул уурхайн ордыг ашиглалтад оруулж, өндөр технологийн хүнд үйлдвэрийн дараах цогцолборуудыг барьж, байгуулна.Үүнд: Уул уурхайн ордууд:<br>Таван толгойн нүүрсний орд;<br>Оюутолгойн далд уурхай; | 2020- 2050 | | Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар ЭБМЗ-ийн орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх зөвлөлийн хуралдаанаар Жоншны 11, Төмрийн 3, Алтны 2, Нүүрсний 2 баяжуулах үйлдвэрийн төслийг хэлэлцэж хүлээн авсан байна. | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дорноговийн цахиурын орд;<br>Цагаан суваргын орд;<br>Хармагтайн орд;<br>Литийн орд;<br>Газрын ховор элементийн хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлнэ.<br>Хүнд үйлдвэр:<br>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр;<br>Нефть-химиu, кокс-химиu, металлургийн үйлдвэр;<br>Нүүрс угаах үйлдвэр;<br>Нүүрс-химиu, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн парк;<br>Ган төмөрлөгийн үйлдвэр;<br>Жонш баяжуулах үйлдвэр;<br>Алт цэвэршүүлэх үйлдвэрийг тус тус барьж байгуулна. | | | | | |
| 11 | | 4.2.24. Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ. | 2020 2050 | - | - | 2025 онд нийт ашигт малтмалын хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө 1191, үүнээс хайгуулын тусгай зөвшөөрөл дээр хийгдэх хайгуулын ажлын төлөвлөгөө 926, ашиглалтын тусгай зөвшөөрөл дээр хийгдэх хайгуулын ажлын төлөвлөгөө 265, 2024 оны хайгуулын ажлын ирүүлсэн тайлан нийт 1084 байна.<br>Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2025.08.08-ны өдрийн байдлаар нөөц хэлэлцүүлэхээр ирүүлсэн 110 хайгуулын ажлын үр дүнгийн тайлангаас хэлэлцсэн 102 үүнээс хүлээн авсан 95 тайлан, буцаасан 7, хэлэлцээгүй 8 байна.<br><br>**УЛСЫН НЭГДСЭН САНД БҮРТГЭГДСЭН АШИГТ МАЛТМАЛЫН ОРД, НӨӨЦ**<br><br>*2025 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар*<br><br>**№ \| Ордын төрөл \| Ордын тоо \| Нөөц: Хэмжих нэгж \| хүдэр/шлих \| металл** | 80 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Алт (үндсэн) | 1 | мян.тн/кг | 16,959.74 | 10,969.57 |
| | Мөнгө | | мян.тн/кг | | |
| | Хар тугалга | | мян.тн | | |
| | Цайр | | мян.тн | | |
| | Зэс | | мян.тн | | |
| 2 | Алт (шороо) | 16 | кг | 2,145.77 | 1,954.29 |
| 3 | Мөнгө | | мян.тн/кг | | |
| | Алт | | кг | | |
| 4 | Зэс | | мян.тн/тн | | |
| | Алт | | кг | | |
| | Мөнгө | | тн | | |
| | Молибден | | мян.тн | | |
| 5 | Төмөр | 4 | мян.тн | 260,903.87 | 106,576.08 |
| | Төмөр | | мян.тн | | |
| | Цайр | | мян.тн | | |
| 6 | Холимог металл | 2 | мян.тн | 3,621.55 | |
| | Зэс | | мян.тн | | 22.36 |
| | Хар тугалга | | мян/тн | | 19.89 |
| | Цайр | | мян/тн | | 28.41 |
| | Алт | | кг | | 519.45 |
| | Мөнгө | | тн | | 91.02 |
| | Кобальт | | тн | | 420.22 |
| | сурьма | | тн | | 681.99 |
| 7 | Никель | | мян.тн/тн | | |
| | Зэс | | тн | | |
| | Кобальт | | тн | | |
| 8 | Гянтболд (үндсэн) | | мян.тн/тн | | |
| 9 | Манган | | мян.тн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | Хайлуур жонш | 10 | мян.тн | 4,169.26 | 1,640.65 |
| 11 | Цайр холимог | | | | |
| | Цайр | | мян.тн | | |
| | Хар тугалга | | | | |
| | Мөнгө | | | | |
| | Кадми | | | | |
| 12 | Уран | | | | |
| 13 | Нүүрс /чулууны үетэй/ | 7 | сая.тн/тн | 134.08 | 152,557,701.92 |
| 14 | Шохойн чулуу | 1 | мян.тн/тн | | 8,781,264.06 |
| 15 | Барилгын чулуу /дайрга/ | 5 | мян.м3 | | 17,981.17 |
| 16 | Боржин | | мян.м3 | | |
| 17 | Өнгөлгөөний чулуу | 1 | мян.м3 | | 1,578.82 |
| 18 | Бал чулуу | 2 | мян.тн/тн | | 15,515.83 |
| 19 | Гөлтгөнө | 2 | мян.тн | | 8,238.79 |
| 20 | Шавар | | мян.м3 | | |
| 21 | Элс хайрга | 14 | мян.м3 | | 9,516.42 |
| 22 | Элс | 4 | мян.м3 | | 6,264.63 |
| 23 | Элсэн чулуу | 1 | мян.м3 | | 3,902.00 |
| 24 | Цеолит | | мян.тн | | |
| 25 | Занар | | мян.м3 | | |
| 26 | Гантиг | 1 | тн | | 78,388,813.20 |
| 27 | Газрын тос | | сая.баррель | | |
| 28 | Цагаан тугалга | | тн | | |
| 29 | Лити | | мян.тн | | |
| | Стронци | | мян.тн | | |
| | Кали | | мян.тн | | |
| | Рубидий | | тн | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 30 | Молибден | | мян.тн/тн | | | |
| | | | | | | | Лити | | тн | | | |
| | | | | | | | ГХЭ-ийн нийлмэл исэл | | тн | | | |
| | | | | | | | цайр | | тн | | | |
| | | | | | | | Цагаан тугалга | | тн | | | |
| | | | | | | | Вольфрам | | тн | | | |
| | | | | | | 31 | Кварц | 1 | мян.тн | 26.39 | 25.56 | |
| | | | | | | 32 | Цахиур | 1 | мян.тн | 2244.64 | 1,901.26 | |
| | | | | | | 33 | Базальт | 1 | мян.тн | | 33,482.34 | |
| | **ДҮН** | | | | | | | | | | | **77.5%** |

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР